



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
НАРИЙНТЭЭЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 02 сарын 11 өдөр

Дугаар А/30

Нарийнтээл сум

Газар эзэмших эрхийн гэрчилгээний
хугацааг сунгах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Захиргааны ерөнхий хуулийн 43.46 дугаар зүйл, Газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1, 37 дугаар зүйлийн 37.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Баянтээг 2-р багийн нэр бүхий 14 иргэний эзэмшлийн 0.98га /9800.0 м²/ өвөлжөө, хаваржааны доорхи газрын газар эзэмших эрхийг 40 жилийн хугацаагаар сунгасугай.

2.Газар эзэмшигчдэд газар эзэмших эрхийн гэрчилгээ олгож, гэрээ байгуулж, улсын бүртгэлд бүртгэхийг газрын даамал (Н.Мягмаржав)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



С.ЦОГТБААТАР



Нарийн тээл сумын засаг даргын 2025 оны
03 сарын 11-ны өдрийн 130 дугаар
захирлын бичиг хавсралт

Газрын эзэмших эрхийн гэрчилгээний хугацаа сунгуулах иргэдийн нэрс

Д/д	Газар эзэмшигчийн				Газрын		
	Эцэг/эх/-ийн нэр	Өөрийн нэр	Регистрийн дугаар	Оршин суугаа хаяг	Газрын хэмжээ /м ² /	Байршил	Зориулалт
1	Бэхбат	Доржлхам	ЙЙ80080619	2-р баг	700	Тал булагийн хөл	Хаваржааны доорхи газар
2	Бэхбат	Доржлхам	ЙЙ80080619	2-р баг	700	Хан-Уулын баруун таримал	Өвөлжөөний доорхи газар
3	Пүрэвсүрэн	Жамсранжав	ЙЙ78022017	2-р баг	700	Ашнай хондлой	Өвөлжөөний доорхи газар
4	Пүрэвсүрэн	Жамсранжав	ЙЙ78022017	2-р баг	700	Хүйтэний улаан мухар	Хаваржааны доорхи газар
5	Дэчинбанди	Олзвой	ЙЙ69112017	2-р баг	700	Бугийн эх өтөг	Өвөлжөөний доорхи газар
6	Дэчинбанди	Олзвой	ЙЙ69112017	2-р баг	700	Улаан хаалат	Хаваржааны доорхи газар
7	Лхагвадулам	Мягмардорж	ЙЙ91061817	2-р баг	700	Модтой өндөрийн сайрын өтөг	Өвөлжөөний доорхи газар
8	Цэрэндорж	Намхайнямбуу	ЙЙ82122211	2-р баг	700	Сэрвэнгийн шанаган	Өвөлжөөний доорхи газар
9	Жавзансүрэн	Амаржаргал	ЙТ77053014	2-р баг	700	Ашнай оройн өтөг	Өвөлжөөний доорхи газар
10	Давагдорж	Төмөрбаатар	ЙЙ69051119	2-р баг	700	Бугийн цагаан хад	Өвөлжөөний доорхи газар
11	Намжилдорж	Охиноо	ЙЙ87080617	2-р баг	700	Шивээтийн нурамт	Өвөлжөөний доорхи газар
12	Намжилдорж	Охиноо	ЙЙ87080617	2-р баг	700	Бэлийн цагаан хад	Хаваржааны доорхи газар
13	Дэчинбанди	Отгонжаргал	ЙЙ79081537	2-р баг	700	Адган зүлэгтийн овоот хүрэн	Өвөлжөөний доорхи газар
14	Дэчинбанди	Отгонжаргал	ЙЙ79081537	2-р баг	700	Адган зүлэгтийн хороо	Хаваржааны доорхи газар



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
НАРИЙНТЭЭЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 оны 03 сарын 13 өдөр

Дугаар А/133

Нарийнтээл сум

Гэрээний хугацааг сунгах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43, 46 дугаар зүйл, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.8 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжих "Ерөнхий боловсролын сургуулийн гал тогооны тоног төхөөрөмж худалдан авах ажил"-ын ӨВАНТСЗДТГ/20240202004 дугаартай тендерийг 2025 оны 03 дугаар сарын 17-ны өдөр хүртэлх хугацаанд гэрээг сунгасугай.

2.Хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Б.Ичинноров)-д даалгасугай.

3.Гэрээнд заасан хуваарь, гүйцэтгэлийн дагуу санхүүжилт олгохыг төсвийн ерөнхий нягтлан бодогч (Г.Наранхүү)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



С.ЦОГТБААТАР



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
НАРИЙНТЭЭЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 оны 03 сарын 17 өдөр

Дугаар А/34

Нарийнтээл сум

Ажил хүлээлцэх, хяналт тавих
ажлын хэсэг байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.4, 48.2.7, Захиргааны ерөнхий хуулийн 43, 46 дугаар зүйлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжигдэж байгаа "Ерөнхий боловсролын сургуулийн гал тогооны тоног төхөөрөмж худалдан авах" ажилд хяналт тавьж, хүлээн авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Б.Түмэндэмбэрэл (ЕБС-ийн захирал)

Гишүүд: Б.Лхамсүрэн (Төсөв, төрийн сангийн мэргэжилтэн)

О.Энх-Амгалан (ЕБС-ийн нярав)

Ж.Ганчимэг (ЕБС-ийн дотуур байрны тогооч)

Б.Нарантуяа (ЕБС-ийн тогооч)

2. Ерөнхий боловсролын сургуулийн гал тогооны тоног төхөөрөмж худалдан авах ажилд хяналт тавьж, хүлээн авч, орон нутгийн өмчид бүртгэн, архивын нэгж бүрдүүлж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч (Б.Түмэндэмбэрэл)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



С.ЦОГТБААТАР



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
НАРИЙНТЭЭЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 оны 03 сарын 18 өдөр

Дугаар А/35

Нарийнтээл сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43, 46 дугаар зүйл, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Нохой устгах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Ц.Мөнх-Эрдэнэ (Цагаан-Овоо 4 дүгээр багийн Засаг дарга)

Гишүүд: Г.Наранхүү (Төсвийн ерөнхий нягтлан бодогч)

Г.Наранбаатар (Байгаль орчны байцаагчийг түр орлон гүйцэтгэгч)

У.Мягмарнасан (Хэсгийн төлөөлөгч, цагдаагийн ахлах дэслэгч)

О.Цэрэннадмид (Шарга 1 дүгээр багийн Засаг дарга)

Б.Базарсад (Баянтээг 2 дугаар багийн Засаг дарга)

О.Мягмар (Өндөрхөмөг 3 дугаар багийн Засаг дарга)

2.Нохой устгалын ажлыг чанартай зохион байгуулж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч (Ц.Мөнх-Эрдэнэ)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



С.ЦОГТБААТАР



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
НАРИЙНТЭЭЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 оны 03 сарын 19 өдөр

Дугаар А/36

Нарийнтээл сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2 дахь хэсэг, 31 дүгээр зүйлийн 31.1.3 дахь заалт, Захиргааны ерөнхий хуулийн 43, 46 дугаар зүйл, Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн "Худалдан авах ажиллагаанд баримтлах төсөвт өртгийн дээд хязгаар тогтоох тухай" 02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1."Сумын хог цэвэрлэх, нохой устгах ажил"-ын гүйцэтгэгчийг сонгох ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Г.Наранбаатар (Бэлчээр, газар тариалан хариуцсан мэргэжилтэн)

Гишүүд: Э.Мөнхбат (Засаг даргын Тамгын газрын нярав)

Б.Ган-Өлзий (Хүүхэд гэр бүлийн нийгмийн ажилтан)

А.Батмөнх (Засаг даргын Тамгын газрын жолооч)

Нарийн бичгийн дарга: Б.Лхамсүрэн (Төрийн сангийн мэргэжилтэн)

2.Бараа ажил үйлчилгээ худалдан авахдаа худалдан авах ажиллагааны хуулийг мөрдөн ажиллахыг ажлын хэсгийн ахлагч (Г.Наранбаатар)-д даалгасугай

ЗАСАГ ДАРГА



С.ЦОГТБААТАР



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
НАРИЙНТЭЭЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 оны 03 сарын 24 өдөр

Дугаар А/37

Нарийнтээл сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43, 46 дугаар зүйл, Ахмад настны тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1, Сангийн сайдын 2021 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 61 дүгээр тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2 дугаар зүйлийн 2.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Сумын төв, Улаанбаатар хот, Арвайхээр суманд зохион байгуулагдсан Ахмадын золголтын арга хэмжээний зардалд 4,116,100 (дөрвөн сая нэг зуун арван зургаан мянга нэг зуун) төгрөгийг зарцуулж тооцоог хавсралтаар баталсугай.

2.Дээрх зардлыг Засаг даргын нөөц сангаас гаргахыг нягтлан бодогч (Ц.Сувд-Эрдэнэ)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



С.ЦОГТБААТАР

Нарийнтээл сумын Засаг даргын 2025
оны 03 дугаар сарын 24 ны өдрийн А/37
дугаар захирамжийн хавсралт



АХМАДЫН ЗОЛГОЛТЫН ЗАРДЛЫН ТООЦОО

№	Материалын нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ /мян.төг/	Бүгд үнэ /мян.төг/
1	Еэвэн	ш	2	25,000	50,000
2	Печень	кг	5	12,000	60,000
3	Чихэр	кг	5	25,000	125,000
4	Хэвийн боорцог	ш	50	5,500	275,000
5	Айраг	л	60	8,000	480,000
6	Цагаан идээ	кг			874,000
7	Ууц /мах/	кг	105,7	13,000	1,3741,00
8	Бяслаг	кг	7,6	30,000	228,000
9	Өрөм	ш	2	25,000	50,000
10	Ус	ш	200	1500	300,000
11	Ундаа	ш	200	1500	300,000
Дүн					4,116,100

_____оОо_____



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
НАРИЙНТЭЭЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 оны 03 сарын 25 өдөр

Дугаар А/38

Нарийнтээл сум

Үнэлгээний хороо байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 34 дугаар зүйлийн 34.1, 45 дугаар зүйлийн 45.5, 48 дугаар зүйлийн 48.2.2 дахь заалт, Захиргааны ерөнхий хуулийн 43.1, 46.1 дүгээр зүйлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Сумын төв болон Баянтээг багийн камеруудыг засварлах, өргөтгөх тендерийн гүйцэтгэгчийг сонгох үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үнэлгээний хорооны дарга: С.Баасандулам (Хууль, эрх зүй асуудал
хариуцсан мэргэжилтэн)

Гишүүд: Н.Мягмаржав (Газрын даамал)
Ч.Галсмаа (СӨББ-ын арга зүйч)
О.Цэрэннадмид (ИТХ-ын төлөөлөгч)

Нарийн бичгийн дарга: Б.Лхамсүрэн (Төсөв, төрийн сангийн мэргэжилтэн)

2. Сумын төв болон Баянтээг багийн камеруудыг засварлах, өргөтгөх ажлыг гүйцэтгэх тендерийн техникийн тодорхойлолт бэлтгэх, тендерийн урилга, тендерийн баримт бичиг боловсруулах, тендер хүлээн авах, нээх, хаах, тендерийг хянан үзэх, үнэлэх, үнэлгээний дүгнэлт гаргах ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж ажиллахыг үнэлгээний хорооны дарга (С.Баасандулам)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



С.ЦОГБААТАР



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
НАРИЙНТЭЭЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 оны 03 сарын 27 өдөр

Дугаар А/39

Нарийнтээл сум

Тендерийн гүйцэтгэгчийг сонгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1, 30.2, 48 дугаар зүйлийн 48.2.6, Захиргааны ерөнхий хуулийн 43, 46 дугаар зүйлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Ажлын хэсгийн 2025 оны 03 дугаар сарын 26-ны өдрийн 01 дүгээр зөвлөмжийн дагуу орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжих "Сумын хог цэвэрлэх, нохой устгах ажил"-ын тендерийг 10,140,000 (арван сая нэг зуун дөчин мянган) төгрөгөөр "Н.Цэнд-Аюуш"-аар гүйцэтгүүлэхийг зөвшөөрсүгэй.

2.Хяналт тавьж гэрээ байгуулж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Б.Ичинноров)-д даалгасугай.

3.Гэрээнд заасан хуваарь, гүйцэтгэлийн дагуу санхүүжилт олгохыг төсвийн ерөнхий нягтлан бодогч (Г.Наранхүү)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



С. ЦОГТБААТАР



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
НАРИЙНТЭЭЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 оны 03 сарын 27 өдөр

Дугаар А/40

Нарийнтээл сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43.1, 46.1 дугаар зүйл, Сангийн сайдын 2021 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 61 дүгээр тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2 дугаар зүйлийн 2.1.1, 2.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Тус суманд хүчтэй шороон шуурга шуурч цахилгааны лонх хагарч унасанаас болж 2 өдөр цахилгаан тасарсан тул аваарын дизелийн түлшний зардалд 337,000 (долоон зуун ерэн таван мянга дөрвөн зуу) төгрөгийг зарцуулж тооцоог хавсралтаар баталсугай.


2.Дээрх зардлыг Засаг даргын нөөц сангаас гаргахыг нягтлан бодогч (Ц.Сувд-Эрдэнэ)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



С. ЦОГТБААТАР

Нарийнтээл сумын Засаг даргын 2025
оны 03 дугаар сарын 27 ны өдрийн АНД
дугаар захирамжийн хавсралт



ЗАРДЛЫН ТООЦОО

№	Материалын нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ /мян.төг/	Бүгд үнэ /мян.төг/
1	Түлш	л	90	3370	303,300
2	А-92	л	12,67	2660	33,700
Дүн					337,000

_____ооо_____